# ХААН СОЁМБО АУДИТ ХХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2023/06/НА-СТА-ТЗШ**

---

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он


Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichko.0808@gmail.com

Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал: Х.Дийммаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Хаан соёмбо аудит ХХК-ийн аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.Аудитын санал дүгнэлт....................3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....................4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....................4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....................5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....................6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....................7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....................9
3. Аудитын тайлан....................9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....................9
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин....................9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....................9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....................10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....................10
4. АУДИТЫН ТАЙЛАН....................11
4.1 Ерөнхий зүйл....................11
4.2 Материаллаг байдал....................11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....................12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....................12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....................12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....................13
5. Аудитын илрүүлэлт....................13
5.2 Төлбөрийн акт....................13
5.3 Албан шаардлага....................13
5.4 Зөвлөмж....................13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....................13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХААХҮЯ | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.20 № 01/82
танай _______________ -ны № _______________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СТАНДАРТ
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Д.БАТЦООЖ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Стандарт хэмжил зүйн газраас 32,564.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 48,304.1 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 64,200.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж ажиллажээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 44 арга хэмжээг хэрэгжүүлж 88 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу

илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,734,500.00** | **5,734,150.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **5,734,500.00** | **5,734,150.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **5,734,500.00** | **5,734,150.00** |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,734,500.00 | 5,734,150.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **152,566,952.68** | **178,944,167.32** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **152,566,952.68** | **178,944,167.32** |
| **392** | **Биет хөрөнгө** | **99,409,452.68** | **125,586,667.32** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 112,358,848.00 | 112,358,848.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -13,928,368.74 | -18,993,230.10 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 51,320,432.00 | 51,320,432.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -51,320,432.00 | -51,320,432.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 14,265,400.00 | 34,354,810.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -14,265,400.00 | -3,387,840.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,377,026.00 | 4,563,771.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -5,398,052.58 | -3,309,691.58 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **53,157,500.00** | **53,357,500.00** |
| 39301 | Програм хангамж | 750,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -750,000.00 | -200,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 53,157,500.00 | 53,157,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **158,301,452.68** | **184,678,317.32** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **158,301,452.68** | **184,678,317.32** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **158,301,452.68** | **184,678,317.32** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 169,019,103.00 | 169,019,103.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 169,019,103.00 | 169,019,103.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **-92,848,593.81** | **-66,471,729.17** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -92,848,593.81 | -92,848,593.81 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 26,376,864.64 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 82,130,943.49 | 82,130,943.49 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **158,301,452.68** | **184,678,317.32** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **203,439,450.00** | **234,997,325.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **51,658,150.00** | **96,764,825.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **51,658,150.00** | **96,764,825.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 59,658,150.00 | 96,764,825.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 51,658,150.00 | 64,200,714.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 32,564,111.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **151,781,300.00** | **138,232,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **149,511,300.00** | **138,232,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 149,511,300.00 | 137,232,500.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 00.00 | 1,000,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,270,000.00** | **00.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,270,000.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **211,393,222.06** | **208,620,460.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **211,393,222.06** | **208,620,460.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **193,014,131.05** | **183,274,734.11** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **141,159,824.13** | **126,905,664.15** |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 141,159,824.13 | 97,573,789.75 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 18,975,439.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 7,205,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 3,151,435.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **18,681,393.86** | **16,459,270.60** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,079,396.86 | 11,444,407.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,438,300.00 | 1,308,353.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,110,318.00 | 1,046,681.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 277,582.00 | 241,802.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,775,797.00 | 2,418,026.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **10,231,547.00** | **9,416,200.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,368,035.98 | 1,201,776.58 |
| 210302 | Түлш, халаалт | 7,270,844.60 | 6,690,252.02 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,592,666.42 | 1,524,171.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,416,830.56** | **7,931,500.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 860,300.00 | 395,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,741,700.00 | 3,989,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,854,100.00 | 2,383,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 387,300.00 | 171,550.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,573,430.56 | 991,850.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **279,200.00** | **394,100.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 279,200.00 | 394,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **240,000.00** | **1,360,200.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 616,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 240,000.00 | 744,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,874,500.00** | **9,374,200.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,874,500.00 | 9,374,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,454,294.00** | **3,170,394.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 320,000.00 | 350,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 176,000.00 | 176,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 161,494.00 | 170,494.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 38,400.00 | 51,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 231,000.00 | 193,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 68,800.00 | 64,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 8,600.00 | 8,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 450,000.00 | 2,157,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,676,541.50** | **8,263,205.36** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 397,000.00 | 318,609.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,113,500.00 | 827,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,166,041.50 | 7,116,896.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **18,379,091.01** | **25,345,726.25** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **480,000.00** | **446,400.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 480,000.00 | 446,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **17,899,091.01** | **24,899,326.25** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,899,091.01 | 11,899,326.25 |
| 213304 | Хөрөнгийн | 00.00 | 13,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-7,953,772.06** | **26,376,864.64** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-7,953,772.06** | **26,376,864.64** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **169,019,103.00** | **82,130,943.49** | **-84,894,821.75** | **166,255,224.74** |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **169,019,103.00** | **82,130,943.49** | **-84,894,821.75** | **166,255,224.74** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -7,953,772.06 | -7,953,772.06 |
| **C08** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **169,019,103.00** | **82,130,943.49** | **-92,848,593.81** | **158,301,452.68** |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **169,019,103.00** | **82,130,943.49** | **-92,848,593.81** | **158,301,452.68** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 26,376,864.64 | 26,376,864.64 |
| **D09** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **169,019,103.00** | **82,130,943.49** | **-66,471,729.17** | **184,678,317.32** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **203,439,450.00** | **202,433,214.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **51,658,150.00** | **64,200,714.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **51,658,150.00** | **64,200,714.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **59,658,150.00** | **64,200,714.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 59,658,150.00 | 64,200,714.00 |
| 120009 | Бусад орлого | -8,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **151,781,300.00** | **138,232,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **149,511,300.00** | **138,232,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 149,511,300.00 | 137,232,500.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 00.00 | 1,000,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,270,000.00** | **00.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,270,000.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **203,439,449.99** | **201,503,214.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **203,439,449.99** | **201,503,214.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **185,060,358.98** | **176,157,487.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **140,943,585.94** | **126,905,664.15** |
| 210101 | Үндсэн цалин | 99,219,286.40 | 97,573,789.75 |
| 210102 | Нэмэгдэл | 31,288,300.17 | 18,975,439.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,435,999.37 | 7,205,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 3,151,435.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **18,872,432.04** | **16,459,270.60** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,285,251.24 | 11,444,407.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,446,834.77 | 1,308,353.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,157,467.52 | 1,046,681.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 289,547.25 | 241,802.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,693,331.26 | 2,418,026.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **10,231,547.00** | **9,416,200.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,368,035.98 | 1,201,776.58 |
| 210302 | Түлш, халаалт | 7,270,844.60 | 6,690,252.02 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,592,666.42 | 1,524,171.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,417,000.00** | **7,931,150.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 830,000.00 | 395,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,646,400.00 | 3,989,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,854,100.00 | 2,383,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 246,500.00 | 171,550.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 840,000.00 | 991,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **420,000.00** | **394,100.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 420,000.00 | 394,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **240,000.00** | **1,360,200.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 616,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 240,000.00 | 744,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,874,500.00** | **9,374,200.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,874,500.00 | 9,374,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,431,294.00** | **3,170,394.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 320,000.00 | 350,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 176,000.00 | 176,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 161,494.00 | 170,494.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 38,400.00 | 51,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 208,000.00 | 193,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 68,800.00 | 64,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 8,600.00 | 8,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 450,000.00 | 2,157,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **630,000.00** | **1,146,309.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 420,000.00 | 318,609.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 210,000.00 | 827,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **18,379,091.01** | **25,345,726.25** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **480,000.00** | **446,400.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 480,000.00 | 446,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **17,899,091.01** | **24,899,326.25** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,899,091.01 | 11,899,326.25 |
| 213304 | Хөрөнгийн | 00.00 | 13,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.01** | **930,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **930,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **930,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **00.00** | **930,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 930,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-930,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **0.01** | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.01** | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 185,536,600.0 | 176,533,887.8 | 9,002,712.3 | 95.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 185,536,600.0 | 176,533,887.8 | 9,002,712.3 | 95.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 185,090,200.0 | 176,087,487.8 | 9,002,712.3 | 95.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 135,295,100.0 | 126,905,664.2 | 8,389,435.8 | 93.8 |
| 210101 | Үндсэн цалин | 102,622,700.0 | 97,573,789.8 | 5,048,910.3 | 95.1 |
| 210102 | Нэмэгдэл | 28,514,400.0 | 18,975,439.4 | 9,538,960.6 | 66.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,158,000.0 | 7,205,000.0 | -3,047,000.0 | 173.3 |
| 210104 | Урамшуулал | 00.0 | 3,151,435.0 | -3,151,435.0 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,912,000.0 | 16,459,270.6 | 452,729.4 | 97.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,500,100.0 | 11,444,407.3 | 55,692.7 | 99.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,353,000.0 | 1,308,353.3 | 44,646.7 | 96.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,082,400.0 | 1,046,681.6 | 35,718.4 | 96.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 270,600.0 | 241,802.2 | 28,797.8 | 89.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,705,900.0 | 2,418,026.2 | 287,873.8 | 89.4 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,416,200.0 | 9,416,200.0 | 00.0 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 999,500.0 | 1,201,776.6 | -202,276.6 | 120.2 |
| 210302 | Түлш, халаалт | 7,092,000.0 | 6,690,252.0 | 401,748.0 | 94.3 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,324,700.0 | 1,524,171.4 | -199,471.4 | 115.1 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,979,500.0 | 6,931,150.0 | 48,350.0 | 99.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 395,600.0 | 395,600.0 | 00.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,989,200.0 | 2,989,200.0 | 00.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,383,300.0 | 2,383,300.0 | 00.0 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 219,900.0 | 171,550.0 | 48,350.0 | 78.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 991,500.0 | 991,500.0 | 00.0 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 394,100.0 | 394,100.0 | 00.0 | 00.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 394,100.0 | 394,100.0 | 00.0 | 00.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,290,200.0 | 2,290,200.0 | 00.0 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 930,000.0 | 930,000.0 | 00.0 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 616,200.0 | 616,200.0 | 00.0 | 00.0 |
| 210604 | Урсгал засвар | 744,000.0 | 744,000.0 | 00.0 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,425,400.0 | 9,374,200.0 | 51,200.0 | 99.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,425,400.0 | 9,374,200.0 | 51,200.0 | 99.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,179,600.0 | 3,170,394.0 | 9,206.0 | 99.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.0 | 350,000.0 | 00.0 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 176,000.0 | 176,000.0 | 00.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 192,800.0 | 170,494.0 | 22,306.0 | 88.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 38,400.0 | 51,500.0 | -13,100.0 | 134.1 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 193,400.0 | 193,400.0 | 00.0 | 00.0 |
| 210807 | Газрын төлбөр | 64,000.0 | 64,000.0 | 00.0 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 8,000.0 | 8,000.0 | 00.0 | 00.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,157,000.0 | 2,157,000.0 | 00.0 | 00.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,198,100.0 | 1,146,309.0 | 51,791.0 | 95.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 370,400.0 | 318,609.0 | 51,791.0 | 86.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 827,700.0 | 827,700.0 | 00.0 | 00.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 446,400.0 | 446,400.0 | 00.0 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 446,400.0 | 446,400.0 | 00.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 446,400.0 | 446,400.0 | 00.0 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 185,536,600.0 | 176,533,887.8 | 9,002,712.3 | 95.1 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 137,232,500.0 | 112,333,173.8 | 24,899,326.3 | -18.1 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 137,232,500.0 | 112,333,173.8 | 24,899,326.3 | -18.1 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 48,304,100.0 | 64,200,714.0 | -15,896,614.0 | 32.9 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 48,304,100.0 | 64,200,714.0 | -15,896,614.0 | 32.9 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 12.00 | 12.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 09.00 | 09.00 | 00.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 | 00.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,000,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,000,000.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,000,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хүний эрүүл мэнд хүрээлэн байгаа орчин бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах экспортыг нэмэгдүүлэх үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хэмжил зүй стандартчилал сорьцын хяналт тохирлын үнэлгээний бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлж чанартай төрийн үйлчилгээг мэргэшсэн чадварлаг хүний нөөцөд тулгуурлан хэрэглэгчдэд хүргэхэд орших зоилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.
Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6 Зорилт 44 арга хэмжээг хэрэгжүүлж 88,1%-ийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

## 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Байгууллагын дотоод хяналт хийх ажил үүргийг албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу ахлах мэргэжилтэн хариуцан ажилладаг байна. Байгууллагын 2022 оны дотоод аудит, хяналт хийх төлөвлөгөөг гаргаж байгууллагын даргаар батлуулан хяналтыг хэрэгжүүлж ажиллажээ. Дотоод хяналтаар тайлант онд үнэт цаасны төлбөр тооцоо болон бэлэн мөнгө хураах тасалбарт тулгалт хийх чиглэлээр хийж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

## 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж тайлагнасан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод материаллаг хэмжээний өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,376.9 мянган төгрөгөөр буюу 16 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 5,734.50 | 5,734.15 | -00.4 |
| Биет хөрөнгө | 99,409.45 | 125,586.67 | 26,177.2 |
| Биет бус хөрөнгө | 53,157.50 | 53,357.50 | 200.0 |
| **Нийт хөрөнгө** | 158,301.45 | 184,678.32 | 26,376.9 |
| Хуримтлагдсан үр дүн | -92,848.59 | -66,471.73 | 26,376.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 158,301.45 | 184,678.32 | 26,376.9 |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, авлага үндсэн хөрөнгө, бараа материал, өр төлбөр гэсэн данс тус бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна. Тайлант онд үндсэн хөрөнгө дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 930.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.
- Стандарт хэмжил зүйн газраас 32,564.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 657 дугаар тогтоолоор 15,567.9 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Хуримтлагдсан үр дүн данс 26,376.9 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд урсгал зардлыг 154,807.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 40,000.0 мянган төгрөгийн өөрийн орлогоос санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 21,522.8 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 133,284.7 мянган төгрөгөөр, өөрийн орлогоос 40,000.0 мянган төгрөгөөр нийт 173,284.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдаж ирсэн байна. Төсөвт 12,251.9 мянган төгрөгөөр тодотгол хийж 185,536.6 мянган төгрөгөөр батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 185,536.6 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвийн хөрөнгөөр 121,335.8 мянган төгрөгийг, өөрийн орлогоос 64,200.7 мянган төгрөгийг санхүүжүүлжээ.

Гүйцэтгэлээр 176,533.9 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 9,002.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал*

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **70407** | **Стандартчилал хэмжил зүй** | **185,536.6** | **176,533.9** | **9,002.7** | **95.1** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагаа | 185,090.2 | 176,087.5 | 9,002.7 | 95.2 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 446.4 | 446.4 | 0.0 | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Засаг даргын Тамгын газраас эталон тоног төхөөрөмж тээвэрлэх зардалд 1,000.0 мянган төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансанд орж зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсвийн эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах тухай болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитор Н.Бадамханд нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 219,393.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4,387.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 3,510.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Худалдан авах ажиллагааны тайлан, 5 сая төгрөгөөс дээших бараа үйлчилгээ худалдан авсан нийлүүлэгчийн нэр хаяг, Өмч хөрөнгө зарцуулах тухай шийдвэрүүдийг мэдээлээгүй, байгууллагын дарга, нягтлан бодогчийн мэдээллийг шинэчлээгүй зэрэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй нийцэхгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 48,304.1 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 64,200.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж ажиллажээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хүргүүлсэн зөвлөмжийг хүргүүлсэн байна. .

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 0.0 | 0 | 0.0 | 0.0 |
| **Нийт дүн** | **1** | **0.0** | **0** | **0.0** | **0.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27,145.0 мянган төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн залруулсан. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 24,899,326.25 төгрөгийн төсвийн тохируулгыг хийгээгүй байсныг залруулсан.
2. Биет хөрөнгө худалдан авсан зардал 930.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байсныг залруулаа.
3. Санхүүгийн байдлын тайлангийн богино хугацаат өр төлбөрийн дүн өглөгийн тодруулгын дүнтэй таарахгүй байна.

Аудитаар нийт 401.5 мянган төгрөгийн зөрчил илэрч 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

### 5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой***

*1.1. Илрүүлэлт:*

Улсын мэдээллийн маягт хэвлэх зардлаас 403.1 мянган төгрөгөөр бичиг хэргийн материал, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 144.0 мянган төгрөгөөр маягт хэвлүүлсэн, бараа үйлчилгээний бусад зардлаас 92.6 мянган төгрөгөөр программын сунгалтын төлбөр төлсөн, 61.8 мянган төгрөгөөр газрын төлбөр тус тус төлсөн Сангийн сайдыг 2019 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан Зарлагын эдийн засгийн ангилал ашиглах заавартай нийцэхгүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах

***2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой***

*2.1. Илрүүлэлт:*

Худалдан авах ажиллагааны тайлан, 5 сая төгрөгөөс дээших бараа үйлчилгээ худалдан авсан нийлүүлэгчийн нэр хаяг, Өмч хөрөнгө зарцуулах тухай шийдвэрүүдийг мэдээлээгүй, байгууллагын дарга, нягтлан бодогчийн мэдээллийг шинэчлээгүй зэрэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй нийцэхгүй байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| | Нийт алдаа | | | Үүнээс |
|---|---|---|---|---|

| Алдааны товч утга | | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Залруулсан | | Залруулаагүй | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн тохируулга хийгээгүй | 1 | 24,889.3 | | | 1 | 24,889.3 | 1 | 24,889.3 | | |
| Хөрөнгө худалдан авсан зардлыг буруу тайлагнасан | 1 | 930.0 | | | 1 | 930.0 | 1 | 930.0 | | |
| Өр төлбөрийн үлдэгдэл тодруулгатай тайлаагүй | 1 | 1,315.7 | | | 1 | 1,315.7 | 1 | 1,315.7 | | |
| **Дүн** | **3** | **27,145.0** | | | **3** | **27,145.0** | **3** | **27,145.0** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн | 1 | 701.5 | | | | | 1 | 701.5 | | | | |
| Дүн | **1** | **701.5** | | | | | **1** | **701.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээллийг мэдээлээгүй | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| Нийт дүн | **1** | **0.0** | | | | | **1** | **0.0** |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:
АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:
АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:
БАТАЛГААЖУУЛСАН:
ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Х.ДИЙМАА
АУДИТОР Н.БАДАМХАНД